



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 67/98

Мөндөгшөө

Сахилгын шийтгэлийг  
арилгах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэг, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийн зургаадугаар бүлгийн 6.5 дахь хэсэг, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.5.2-ийн "г" дэх заатыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн цагдаа-жолооч, цагдаагийн ахлагч Ганбатын Шатаррагчаа нь гаргасан зөрчлөө ухамсарлаж "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм", "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм", "Байгууллагын дотоод журам"-аар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн ажлаараа хамт олноо манлайлж онцгой гавъяа байгуулсан тул цагдаагийн ахлагч Г.Шатаррагчааг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс сахилгын шийтгэлгүйд тооцсугай.

2. Тушаалыг алба хаагчдад танилцуулж, тушаалын хувийг алба хаагчийн хувийн хэрэгт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн ахмад Б.Батцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Цагдаагийн ахлагч Г.Шатаррагчаагийн цалин хөлсийг зохих журмын дагуу олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



40003836



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 5/79

Мандалговь

Цалин тогтоох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код-924/ 924.4.2, мөн даргын А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.4.2-ийн "б", "в"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 07 сарын 10-ны өдрийн Б/537 дугаар тушаалаар Замын цагдаагийн тасагт зохицуулагчаар томилогдсон цагдаагийн хошууч Төмөрийн Ганбаярыг төрийн тусгай алба хаагчдын цалингийн сүлжээний ТТ9-ийн 5 дугаар шатлалаар цалинжуулж, цолны нэмэгдлийг 30, онцгой албаны нэмэгдлийг 25, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувиар тооцож олгосугай.

2. Цагдаагийн хошууч Т.Ганбаярын цалинг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн  
дарга, цагдаагийн  
дэд хурандаа

Л.Баярсайхан



40000816



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 6/81

Мандалговь

Албан үүргийг түр орлон  
гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246, А/248 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.5.2-ын "г", "Албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгэх" журам /код-906/ 906.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цагдаагийн газрын хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Энхмандал 2019 оны 07 сарын 02-ны өдрөөс 2019 оны 08 сарын 05-ны өдрийг хүртлэх хугацаанд ээлжийн амралт эдэлж байгаа тул ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ц.Даваадоржийг 2019 оны 07 сарын 02-ны өдрөөс 2019 оны 08 сарын 05-ны өдрийг хүртлэх хугацаанд Хэрэг бүртгэх тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Хэрэг бүртгэх тасгийн даргын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолттой танилцан судалж, хэрэгжүүлж ажиллахыг Хэрэг бүртгэх тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ц.Даваадорж/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:

Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 3/22

Мандалговь

Ажилд томилж цалин  
тогтоох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код-924/ 924.4.2, "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх" журам /код-900/ 900.3.2-ын "г", мөн даргын А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.4.2-ийн "б", "в"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн даргын 2019/123 дугаар мэдэгдлээр тус цагдаагийн газарт ажиллах зөвшөөрөл олгогдсон Энхээгийн Баярсайханыг 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаагаар томилж, цагдаагийн дэд ахлагч цол олгосугай.

2. Цагдаагийн дэд ахлагч Э.Баярсайханыг төрийн тусгай алба хаагчдын цалингийн сүлжээний ТТ7-ийн 2 дугаар шатлалаар цалинжуулж, цолны нэмэгдлийг 25 хувиар, онцгой албаны нэмэгдлийг 25 хувиар тооцож олгосугай.

3. Цагдаагийн дэд ахлагч Э.Баярсайханы цалинг 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн,  
Захиргааны удирдлагын тасгийн  
дарга, цагдаагийн  
дэд хурандаа

Л.Баярсайхан



40003830



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 5/23

Мандалгоо

Алба хаагчдын цалинг  
нэмж, бууруулж олгох тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.4.2-ийн "в", "Алба хаагчийн ажлыг үнэлэх" журам /код-111/, 111.4.2, Цагдаагийн газрын даргын 2016 оны Б/19 дүгээр тушаалаар батлагдсан "Ажил дүгнэх журам"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2019 оны 07 дугаар сард үндсэн үүргээ хангалттай сайн гүйцэтгэсэн нэр бүхий алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар нэмж олгосугай. Үүнд:

1. х/ч Т.Розон	30	12. а/а М.Батболор	5
2. а/х Б.Мягмарсүрэн	20	13. а/а С.Энхтүвшин	5
3. а/д А.Ганзориг	20	14. д/а Б.Насанжаргал	5
4. а/д Ш.Бямбасүх	20	15. а/а Ч.Эрдэнэбулган	5
5. а/х Н.Ганбат	10	16. а/а Л.Баттөр	5
6. а/х Б.Батцэцэг	10	17. д/а Б.Ууганбаатар	5
7. а/х Б.Гантуяа	10	18. а/а Х.Энэбиш	5
8. а/д Х.Ганчимэг	10	19. а/ч Э.Мөнхбаяр	5
9. а/д Б.Өнөрболд	5	20. д/а Б.Тэгш-Ерөөлт	5
10. а/а М.Бат-Эрдэнэ	5	21. д/а Б.Чойжамц	5
11. а/а Ш.Ууганбаяр	5	22. д/а О.Анхбаяр	5

2.2019 оны 07 дугаар сард үндсэн болон нийтлэг үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн доорхи алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар бууруулж олгосугай. Үүнд:

1. д/ч Л.Отгонбаатар	20	5. а/д Т.Адъяабат	10
2. д/а Х.Хаянхярваа	20	6. д/ч С.Батбаяр	10
3. д/а Б.Цэндсүрэн	20	7. а/ч Е.Алтанзул	10
4. а/х Х.Амарзаяа	10		

3.Цагдаагийн газрын дотоод журмын 2.2-д заасны дагуу нөхцөл байдлаа илтгээгүй, өглөөний рапорт, түргэн цугларалт тасалсан, ээлж хүлээлцэхэд ирээгүй нэр бүхий алба хаагчдын цалинг нэг сарын үндсэн цалингийн заасан хувиар бууруулж олгосугай. Үүнд:

1. х/ч Ш.Цэндбаатар	4	5. а/д М.Батболд	2
2. а/ч У.Мэнджаргал	4	6. а/д З.Жаргал	2
3. х/ч М.Уламбаярлах	2	7. а/д М.Бат-Эрдэнэ	2
4. а/х Д.Баттулга	2	8. д/ч С.Батбаяр	2

40003833

9. д/ч Х.Доржбямба 2 ✓  
10. д/ч Б.Билгүүн 2 ✓  
11. а/а Б.Сугирдорж 2 ✓  
12. а/ч Э.Ванчиндорж 2 ✓  
13. а/ч М.Зандраа 2 ✓  
14. а/ч Ш.Жавхлантөгс 2 ✓

15. а/ч О.Эрдэнэ 2 ✓  
16. д/а Б.Далхсүрэн 2 ✓  
17. д/а Х.Хаянхярваа 2 ✓  
18. д/а Б.Чойжамц 2 ✓  
19. д/а О.Анхбаяр 2 ✓  
20. д/а Б.Цэндсүрэн 2 ✓

4. Дээрхи нэр бүхий алба хаагчдын цалингийн хэмжээг 2019 оны 07 дугаар сард бууруулж олгохыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 5/184

Мандалговь

Сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь хэсэг, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл ногдуулах" журмын 914.3.4, А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журмын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ийн "г" дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус цагдаагийн газрын Баянжаргалан сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Чүлтэмийн Батсүх нь цагдаагийн газрын даргатай байгуулсан илтгэлцлийн гэрээний хавсралтын 3, 8 дахь хэсэг, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2.4.6, 2.4.10-д заасан хэм хэмжээг зөрчсөн тул "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийн 12.15-д заасныг баримтлан албан тушаалын сарын үндсэн цалинг 2 /хоёр/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Цагдаагийн ахмад Ч.Батсүхийн цалинг 2019 оны 07 дугаар сард тушаалд заасан хувиар бууруулж олгохыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалыг цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулж тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан



40003811



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 8/85

Мандалговь

Цалинтай чөлөө  
олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэг, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код-136/ 136.5.2-ийн "г", мөн даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Алба хаагчид чөлөө олгох" журам /код 934/-ын 934.2.3-ын "б", "в", "д"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хот явах хувийн чөлөө хүссэн эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч цагдаагийн ахмад Б.Гантуяад 2019.07.03-2019.07.05-ныг дуустал ажлын 3 хоног, харуулын цагдаа, цагдаагийн сургагч ахлагч Ц.Одбаярт 2019.07.18-2019.07.19-нийг дуустал ажлын 2 хоног, зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн ахлагч Е.Алтанзулд 2019.07.18-2019.07.19-нийг дуустал ажлын 2 хоног, ар гэрт нь гачигдал гарсан бичээч, бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн дэд ахлагч Б.Цэндсүрэнд 2019.07.08-2019.07.10-ныг дуустал ажлын 3 хоног, эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч, цагдаагийн ахмад Б.Гантуяад 2019.07.25-2019.08.05-ныг дуустал ажлын 8 хоног, нярай хүүхэд асрах чөлөө хүссэн сантехникч Т.Билэгсайханд 2019.07.23-2019.07.29-ийг дуустал ажлын 5 хоногийн цалинтай чөлөөг тус тус олгосугай.

2. Алба хаагчдын цалинг зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хувийг алба хаагчдын хувийн хэрэгт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн ахмад Б.Батцэцэг/, Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



40003506





ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗАР ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 5/86

Мандалговь

Сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь хэсэг, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл ногдуулах" журмын 914.3.4, А/246 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журмын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ийн "г" дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус цагдаагийн газрын Өлзийт сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Цогбадрахын Азбаяр нь Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5 дахь хэсэг, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2.4.6, 2.4.13-д заасан хэм хэмжээг зөрчсөн тул "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийн 12.15-д заасныг баримтлан албан тушаалын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Цагдаагийн дэслэгч Ц.Азбаярын цалинг 2019 оны 07 дугаар сард тушаалд заасан хувиар бууруулж олгохыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалыг цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулж тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Л.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

О.АМАРСАНАА

Хуулбар үнэн:  
Захиргааны удирдлагын тасгийн дарга,  
цагдаагийн дэд хурандаа

Л.Баярсайхан



40003828